

ЭС СОНГОХ ЭРХ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН НӨЛӨӨЛӨЛ

Д.Ундрах,

*МУИС-ийн УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим, дэд профессор
Orcid:0009-0009-8506-8672*

Э.Сайхантуяа

МУИС-ийн УТСОУХНУС, Улс төр судлалын тэнхим магистрант /

Abstract: *After more than 30 years of guaranteeing Mongolian people's right to vote and be elected by the Constitution, Mongolians are going to participate in the 9th election in 2024 and enjoy their rights. In addition, less than 10 years have passed since the laws and regulations recognized that human beings have the right not to vote, and amendments were made to the relevant election laws.*

Within the framework of this research, whether or not the actions with political goals carried out by the media in Mongolia had a direct impact on the election results, whether it is an attack on the right of citizens to vote, an attempt to manipulate the psychology of voters, and whether it is allowed by the ethical principles and norms of the media aims to raise the issue systematically from a scientific point of view.

Keywords: *Elections, representative democracy, null voting, manipulation, mass media*

Эс сонгох эрх ба нэр томъёоны асуудал

Хүний сонгох, сонгогдох эрхийн үзэл санаа нь Социологийн шинжлэх ухааны хөгжлийн үндсэн хөшүүргүүдийн нэг гэлтэй. Учир гэвээс, социологи нь нийгмийн бодит баримт сэлт болон шүүмжлэлт шинжилгээнд тулгуурлан хөгждөг мөн чанарынхаа үүднээс тоталитар дэглэмийн үед бүрэн утгаараа түгэн дэлгэрэх боломжгүй юм. Тиймдээ ч засаглалын монарх ёсыг халж, Бүгд найрамдах засаглалын эхийг тавьсан гэгддэг Францын хөрөнгөтний хувьсгал Социологийн шинжлэх ухаан өнөөгийн хөгжилдөө хүрэх улс төрийн үндсэн хүчин зүйл нь байжээ (О.Мөнхбат 2008). Энэ үед тунхагласан шударга ёс, тэгш эрхийн үзэл санааны нөлөөгөөр нийгмийн оюун санаа илүү иргэнлэг үнэт шинж рүүгээ дөхөж, улмаар шинжлэх ухааны сэтгэлгээнд ч шинийг эрэлхийлэх таатай нөхцөл бүрдэж эхлэв. Мөн энэ үеийн хувьсгалын үр дүнд 21 ба түүнээс дээш насны франц иргэдэд сонгох эрх олгосон зэрэг тунхагууд нь өнөөгийн Ардчиллыг хөгжүүлэхэд асар их үүрэг гүйцэтгэсэн түүхтэй.

Энэ цагаас хойш дэлхийн өнцөг булан бүрд Ардчиллын давалгаанууд өрнөсөөр, ардчилагдах үйл явц олон саад бэршээлийг туулсаар өдгөө хүн төрөлхтөн үндэс угсаа, арьс өнгө, шашин шүтлэг, нийгмийн гарал ялгалгүйгээр улс орныхоо төрийн үйл хэрэгт шууд оролцох, эсвэл шууд бусаар буюу сонгох эрхээ эдлэх төлөөллийн Ардчиллын зарчмыг хэрэгжүүлж байна.

Төлөөллийн Ардчилал гэж иргэд хууль тогтоох байгууллагынхаа гишүүнийг сонгох замаар төрийн эрх мэдлийг атгаж буй үйл явц юм. Гэвч төлөөллийн Ардчиллын зарчмыг хэрэгжүүлж буй улс орон бүрд хурцаар хөндөгдөх болсон үзэгдэл нь protest vote буюу эсэргүүцлийн санал, бидний нэршиж ирснээр “цагаан сонголт” нь улс төрийн намуудын хувьд тархи гашилгасан асуудал хэвээр байна.

Сонгуулийн үйл явц дахь эсэргүүцлийн санал гэх ойлголт анх Баруун Германаас эхлэлтэй гэж үздэг. (R., The significance of void ballots in West German elections, 1965) Баруун Германд 1957 болон 1961 онд болсон сонгуульд иргэд нь тэмдэглэлгүй хоосон хуудас ихээр өгсөн тул удаах сонгуулиудад хоосон саналын хуудас хураалгахыг хориглох шийдвэрийг эрх баригчид нь гаргаж байжээ. 1957, 1961 оны сонгуулиудад хоосон саналын хуудас хураалгасан сонгогчдыг судлаач

Р.Стэйфболд хоёр ангилж үзсэн байна. *Нэгдүгээрт*, хайхрамжгүй сонгогчид буюу төрийн хүчтэй дарамтаас болж санал хураалтын өдөр биечлэн очсон боловч төрийн тогтолцооны талаар ойлголт мэдлэг дутмаг, тодорхой саналгүй учраас саналын хуудсыг бөглөлгүй орхисон. *Хоёрдугаарт*, улс төрийн мэдлэгтэй, үзэл хандлага нь тогтсон хэсэг бүлэг иргэд аль ч сонголтыг хийсэн аж амьдралд нь сайн нөлөө авчрахгүй гэж итгэсэн тул эсэргүүцлээ илэрхийлэн хоосон болон хүчингүй санал өгсөн байна (R., The significance of void ballots in West German elections, 1965). Үүний дараа эсэргүүцлийн санал буюу хоосон хуудсыг сонгууль бүрийн хэвшмэл санал болтол хэрэгжүүлсэн улс бол Францын бүгд найрамдах улс. Францын Ерөнхийлөгчийн 1969-1988 онуудад болсон дөрвөн удаагийн сонгуулийн санал хураалтын дүн тус бүрд эзлэх хоосон саналын тоо өндөр түвшинд байсан талаар мөн судалгааны дүгнэлт өгүүлж байна (Rosenthal H, 1973). Хожмоо Эммануэль Макроны ялалт байгуулсан 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд эсэргүүцлийн саналын тоо 1969 оноос хойш хамгийн олон тоологдсон болохыг олон улсын агентлагууд мэдээлж байлаа. Тус сонгуульд 4 сая иргэн буюу нийт сонгогчдын 12.7 хувь нь бидний нэрлэдгээр “цагаан сонголт” хийсэн байв. Цаашлаад 1980 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд Латин Америкийн улс орнуудад болсон Ерөнхийлөгчийн сонгуулиудад оролцсон сонгогчдын саналын дунджаар авч үзвэл, хүчинтэй саналын 5.5 хувийг “цагаан сонголт” тогтмол эзэлсээр иржээ (C., 2016). Энэ мэт сонгуулиас сонгуулийн туршид “цагаан сонголт”-ын тоо нэмэгдэж, иргэдийн улс төрийн эсэргүүцлээ илэрхийлэх арга хэрэгсэл болсоор буй туршлага олон улс хийгээд манай оронд элбэг ажиглагдаж байна.

Эсэргүүцлийн санал дэлхий нийтэд 4 хэлбэрээр илэрч байгааг “Эсэргүүцлийн саналын ангилал зүй” тойм бүтээлд онцолсон байна (R. Michael Alvarez, 2018). Үүнд:

1. сонгогч нь сонгуульд ялах боломж багатай нам эвсэл, нэр дэвшигчид зориудаар санал өгөх,
2. сонгогч нь саналын хуудсыг бөглөлгүй хоосон орхих, эсвэл NOTA /none of the above/ буюу “дээрхийн аль нь ч биш” сонголтыг дугуйлах, */Зураг 1/*
3. саналын хуудсыг ураг, зарим практикт идэх ч тохиолдол гардаг ба энэ мэт хууль бус үйлдлээр эсэргүүцлээ илэрхийлэх,
4. санал авах байранд санаатайгаар очихгүй байх замаар төр улсдаа итгэл алдарснаа

илэрхийлж байна гэж ангилжээ.

Зураг 1. Энэтхэгийн Хууль тогтоох ассамблейн сонгуулийн саналын хуудас, 2018 он



Эх сурвалж: www.livemint.com Линк: [Who votes 'None of the Above' in India | Mint \(livemint.com\)](http://www.livemint.com)

Олон улсын ангиллаас харахад, монголчуудын эсэргүүцлийн санал нь хоосон саналын хуудас өгөх хувилбараар илэрч байна. Монгол Улсад 2013 оноос өмнө саналын хоосон хуудсыг хүчингүйд тооцож, сонгогчийн сонгуулийн байрнаа биечлэн ирж өгсөн санал үнэгүүддэг байв. Харин 2012 онд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд, 2015 онд Сонгуулийн тухай хуульд тус тус нэмэлт,

өөрчлөлт оруулснаар⁵⁹ “цагаан сонголт” гэх улс төрийн харилцааны шинэ мэт хуучин үзэгдлийг хууль, эрх зүйн хүрээндээ хүлээн зөвшөөрсөн алхам болжээ. Сүүлийн жишээ дурдвал, 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтын дүнгээр нэр бүхий нэр дэвшигчийн авсан нийт саналын тоо болоод “цагаан сонголт”-ын тоо хооронд ердөө 831 саналын зөрүү гарсан нь⁶⁰ монголчуудын эсэргүүцлийн санал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлан тогтоож, урган гарах үр дагаврыг олон улсын туршлагын үүднээс тооцоолон дүгнэх зайлшгүй шаардлага үүссэнийг харуулж байна.

Нөгөө талаас олон улсад сонгогчийн саналаа эс өгөх эрхийг хүний эрхийн үүднээс хүндэтгэн үзэж, саналын хуудаснаа *NOTA /none of the above/* буюу “дээрхийн аль нь ч биш” сонголтыг сонгогчдод санал болгосоор 10 гаруй жилийн хугацаа өнгөрч байхад харин манай улсад төлөөлүүлж буй нэр томьёо нь анх нэр нь үл мэдэгдэх нийтлэлчийн хэрэглэсэн нэршил болох “цагаан сонголт” гэх үгээр иргэдийн эсэргүүцлийн саналыг илэрхийлсээр иржээ. Монголчуудын “цагаан сонголт” гэх хоосон хуудсын тухай тодорхойлолтын цаана дэлхий дахинд 4 хэлбэрээр илэрч буй иргэний улс төрийн эсэргүүцэл, сонгох эрхийн зөрчлүүд, цаашлаад тус бүрд нь шинжлэн судлах шаардлага бүхий харьяалах шинжлэх ухааны асуудлууд хүлээгдэж байна. Тодруулбал, утга уянгын энэхүү нэршил дор эсэргүүцлийн санал хэмээх ойлголтыг зөвхөн хоосон саналын хуудас төдийд илэрхийлсээр байгаа нь улс төр хийгээд хэл зүйн шинжлэх ухаанд судалгаа шинжилгээ үгүйлэгдэж буйг илтгэж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгогчдын “цагаан сонголт”-д шууд нөлөөлсөн нь...

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж олон нийтийг мэдээ, мэдээллээр шуурхай-тогтмол хангах зорилго бүхий өөрийн гэсэн редакцитай өдөр тутмын сонин, сэтгүүл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, цахим хэвлэл зэргийг хэлнэ.⁶¹ Эл тодорхойлолтын үүднээс Монголын хэвлэл мэдээллийн томоохон хэрэгслүүдийн нэг болох www.ikon.mn мэдээллийн сайтаас 2017 оны Ерөнхийлөгчийн дахин сонгуулийн 10 хоногийн хугацаанд өрнүүлсэн “Цагаан сонголт” акцид шинжилгээ хийв.

Тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн сануулахад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн санал хураалтын дүн 6 сарын 26-ны өдөр гарсан. Нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын 50+ хувийн санал авч чадаагүй учраас Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дагуу Дахин сонгууль явуулах болов. Улмаар энэ өдрийн маргааш буюу 6 сарын 27-нд хэвлэл мэдээллийн www.ikon.mn сайт “Цагаан сонголт” уриалга, “Цагаан сонголт” хөдөлгөөн өрнүүлж байгаагаа цахим сайтдаа болон нийгмийн сүлжээн дэх албан ёсны хуудсуудаараа дамжуулан мэдээлжээ. (www.ikon.mn, 2017)

Дахин сонгуулийн санал авах өдөр хүртэл 10 хоногийн хугацаанд тус сайтад нийтлэгдэж, цахим орчинд түгсэн нийтлэлүүдэд контент анализ хийж үзэхэд, нийт 12 нийтлэлийг сэтгүүл зүйн бичлэгийн мэдээ, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, ярилцлагын төрлөөр нэвтрүүлсэн ба зөвхөн Фэйсбүүк дэх *ikon news* албан ёсны хуудастаа түгээсэн мэдээлэлд нь 5353 хариу үйлдэл/reaction, 2780 сэтгэгдэл, 719 удаа хуваалцсан байв. Харин сайт болон Твиттер орчноос бусдад хуваалцсан тоо нь нууцлалын тохиргоотой байжээ.

Дээрх хугацаанд “Цагаан сонголт” уриалгыг хэвлэл мэдээллийн зарим хэрэгслүүд дэмжсэний дотор ТВ9, Mongol HD, Eagle News телевизүүд тодорхой хэмжээнд дэмжиж мэдээ цацсан байна. Харин С1 телевиз эрс шүүмжлэн эсэргүүцэж, мэдээ түгээжээ. Мөн МАХН-аас нэр дэвшигч 6 сарын 30-ны өдөр


⁵⁹ Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 55.10.-т, Сонгуулийн тухай хуулийн 97.9.-т “Сонгогч нэг ч нэр дэвшигчийн төлөө санал өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолох ба энэ тохиолдолд уг саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцно” гэх заалтыг тус тус нэмэлтээр оруулсан.

⁶⁰ 72569 сонгогч нэр дэвшигч С.Эрдэнийн төлөө санал өгсөн бол 71738 иргэн “цагаан сонголт” өгчээ. СЕХ тайлан. 2021

⁶¹ Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн зарчим. 2019 *Invalid source specified.*

хийсэн хэвлэлийн бага хурлын үеэрээ “Цагаан сонголт” уриалгыг дэмжиж буйгаа илэрхийлээд сонгогчдыг мөн дахин сонгуульд хоосон саналын хуудас өгөхийг уриалсан байв. (байна, 2017) Ийнхүү Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны дахин сонгуулийн санал хураалтын албан ёсны нэгтгэсэн дүнг 7 сарын 9-ны өдөр Сонгуулийн Ерөнхий хорооны цахим хуудаст байршуулахад, АН-ын нэр дэвшигч 611,255 санал буюу сонгогчдын 50.61 хувийн дэмжлэг, МАН-ын нэр дэвшигч 497,067 санал буюу 41.16 хувь, Цагаан сонголт 99,494 сонгогч буюу 8.23 хувийг тус тус эзэлсэн байв (хороо, 2017). *График 1, Хүснэгт 1.*

График 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны дахин сонгуулийн дүн, хувийн жингээр




Хүснэгт 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны дахин сонгуулийн дүн

№	Аймаг, дүүргийн сонгуулийн хороо	Нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн		Үүнээс						
			тоо	хувь	М.Энхболдын төлөө өгсөн саналын		Х.Баттулгын төлөө өгсөн саналын		Санал огт тэмдэглээгүй саналын хуудасны		
			тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
1	Архангай	59648	35340	59.26	15519	43.91	16763	47.43	3058	8.65	
2	Баян-Өлгий	58991	38470	65.21	21306	55.38	16201	42.11	963	2.50	
3	Баянхонгор	54271	35705	65.79	11944	33.45	23085	64.65	676	1.89	
4	Булган	39978	23159	57.93	9360	40.42	11568	49.95	2231	9.63	
5	Говь-Алтай	36014	20575	57.13	10793	52.46	8334	40.51	1448	7.04	
6	Говь-Сүмбэр	10413	6561	63.01	3331	50.77	2764	42.13	466	7.10	
7	Дорноговь	42932	25987	60.53	12456	47.93	11657	44.86	1874	7.21	
8	Дорнод	50225	26273	52.31	10271	39.09	13535	51.52	2467	9.39	
9	Дундговь	29314	17382	59.30	8243	47.42	6420	36.93	2719	15.64	
10	Завхан	45313	29869	65.92	13993	46.85	14632	48.99	1244	4.16	
11	Өвөрхангай	72817	41700	57.27	20209	48.46	19001	45.57	2490	5.97	
12	Өмнөговь	41845	21308	50.92	8412	39.48	10258	48.14	2638	12.38	
13	Сүхбаатар	39243	23969	61.08	10860	45.31	11628	48.51	1481	6.18	
14	Сэлэнгэ	70035	41626	59.44	20032	48.12	18381	44.16	3213	7.72	
15	Төв	61214	36206	59.15	19192	53.01	14562	40.22	2452	6.77	
16	Увс	49439	31027	62.76	17367	55.97	12172	39.23	1488	4.80	
17	Ховд	51638	29783	57.68	14451	48.52	13135	44.10	2197	7.38	
18	Хөвсгөл	83054	49058	59.07	21550	43.93	24135	49.20	3373	6.88	
19	Хэнтий	47357	26889	56.78	9658	35.92	14452	53.75	2779	10.34	
20	Дархан-Уул	65126	36227	55.63	16154	44.59	16496	45.54	3577	9.87	
21	Орхон	66947	37266	55.66	12452	33.41	20042	53.78	4772	12.81	
Аймгийн дүн			1075814	634380	58.97	287553	45.33	299221	47.17	47606	7.50
22	Баянгол	137548	87996	63.97	29102	33.07	51596	58.63	7298	8.29	
23	Баянзүрх	218719	137485	62.86	49030	35.66	75765	55.11	12690	9.23	
24	Сүхбаатар	91444	58694	64.19	20717	35.30	32634	55.60	5343	9.10	
25	Сонгинохайрхан	201384	126347	62.74	50343	39.85	64272	50.87	11732	9.29	
26	Хан-Уул	106910	67707	63.33	23476	34.67	38047	56.19	6184	9.13	
27	Чингэлтэй	106173	64429	60.68	23382	36.29	34807	54.02	6240	9.69	
28	Налайх	23753	15332	64.55	7068	46.10	6979	45.52	1285	8.38	
29	Багануур	19106	10864	56.97	4791	44.02	5193	47.71	900	8.27	
30	Багахангай	2737	1857	67.85	1108	59.67	682	36.73	67	3.61	
Нийслэлийн дүн			907774	570731	62.87	209017	36.62	309975	54.31	51739	9.07
Гадаад дахь сонгогч			7209	2676	37.12	497	18.57	2030	75.86	149	5.57
НЭГДСЭН ДҮН			1990797	1207787	60.67	497067	41.16	611226	50.61	99494	8.23

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий хороо, 2017 линк: [ТАНИЛЦ: Сонгуулийн ирц, саналын тооны ЗАДАРГАА \(ikon.mn\)](#)

10 хоногийн зайтай явуулсан хоёр санал хураалтад эзлэх хоосон саналын хуудас буюу “цагаан сонголт”-ын тоо 81 мянган саналаар “бүл нэмсэн” нь манай улсын төлөөллийн Ардчиллын түүхэнд байгаагүй огцом өсөлт болов. *График 2, Хүснэгт 2.*

График 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн нэг болон хоёр дахь санал хураалтын дүн дэх “цагаан сонголт”-ын хувийн жингийн харьцуулалт



Хүснэгт 2. Нэг болон хоёр дахь санал хураалтад эзлэх “цагаан сонголт”-ын дүн, байршлаар

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2017 ОНЫ СОНГУУЛЬ	НИЙСЛЭЛД	ОРОН НУТАГТ	ГАДААДАД	НИЙТ
Эхний санал хураалт дахь хоосон саналын дүн	9985 (1.57%)	8625 (1.2%)	53 (1.1%)	18663 (1.38%)
Дахин санал хураалт дахь хоосон саналын дүн	51739 (9.07%)	47606 (7.5%)	149 (5.27%)	99494 (8.23%)

Эх сурвалж: СЕХ

Хэвлэл мэдээллийн хэрэгслээс олон нийтэд эс сонгохыг уриалах байдал олон улсад:

Судалгааны эсдвийн хүрээнд иргэдийн эс сонголтад хэвлэл мэдээллийн хэрэгслээс санаатайгаар буюу редакцийн бодлогоороо нөлөөлөх оролдлого хийсэн туршлага олон улсад байдаг эсэхийг интернэтэд суурилсан бүрэн текстийн мэдээллийн сангуудаас хайлт хийсэн боловч олдоогүй. Харин XXI зуун гарснаас хойш дэлхийн нэлээд улсад эрчимтэй ажиглагдах болсон “Зохион байгуулалттай эсэргүүцлийн санал” гэх улс төрийн манипуляци ажиллагаанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нөлөөлөгч арга хэрэгсэл нь болж ашиглагдсаар буй талаар судалгааны дүн өгүүлж байна. (R. Michael Alvarez, 2018)

Тодруулбал, аливаа нам эвсэл, нэр дэвшигч, сөрөг хүчний зүгээс улс төрийн зорилгоор /ялангуяа сонгуулийн үеэр/ иргэдэд хоосон санал өгөхийг уриалахдаа хэвлэл мэдээллийн

хэрэгслүүдэд санхүүгийн хувьд нөлөөлөх байдлаар талдаа ажиллуулахыг “Зохион байгуулалттай эсэргүүцлийн санал” /organized protest voting/ хэмээн олон улсын судалгаануудад нэршиж байна. Энэ төрлийн ажиллагаанаас жишээ таввал:

Перу улсын Ерөнхийлөгчийн 2000 оны сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын 50+ хувийн санал аваагүй тул дахин санал хураалт явуулах эрх зүйн шаардлага үүссэн байна. Тухайн үеийн хүчтэй нэр дэвшигч болох Альберто Фужимори нь 1990 онд төрийн эргэлт хийснээр Ерөнхийлөгчийн албан тушаалд сонгогдсоноос хойш 10 жил тасралтгүй эрх мэдлээ нэгтгэсэн нэгэн байв. Гэвч сонгуулийн олон улсын ажиглагчид болон түүний өрсөлдөгч Peru possible намаас нэр дэвшигч Алехандро Толедогийн зүгээс Альберто Фужимориг улс төрийн эрх мэдлээ ашиглан төрийн нөөцийг сонгуулийн кампанит ажилдаа зарцуулсан, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хяналтдаа ажиллуулсан, санал тоолох явцад зөрчил гаргасан зэрэг хэд хэдэн үндэслэлээр буруушаав.

Ийнхүү Ерөнхийлөгч асан Альберто Фужимори олон улсын сонгуулийн ажиглагчдын хурц хараанд онилогдсон цаг хугацааг өрсөлдөгч Алехандро Толедо соргоогоор ашиглаж, төрийн хяналтаас түр хугацаанд “чөлөөлөгдсөн” хувийн мэдээллийн хэрэгслүүдэд санхүүгийн хувьд нөлөөлж, нийт иргэдэд цагаан сонголт хийхийг эрчимтэй уриалж эхэлжээ. Ингэхдээ салбар бүр дэх төрийн хатуу хяналт, авлигын асуудал, сонгуульд нөлөөлөх гэсэн оролдлогуудыг эсэргүүцэж, хоосон санал өгөхийг нийгмийн нөлөөлөгчид болон сэтгүүлчдээр дамжуулан уриалах болсон байна. Ийнхүү Перугийн Ерөнхийлөгчийн 2000 оны сонгуулийн хоёр дахь шатны санал хураалтын дүн гарахад нийт саналд эзлэх хоосон саналын хуудасны тоо 31 хувийг давсан нь *График 3* “Зохион байгуулалттай эсэргүүцлийн санал” ажиллагааны тод жишээ болж байна. (GD., 2002)

График 3. Перу улсын Ерөнхийлөгчийн 2000 оны сонгуулийн хоёр шатны санал хураалт дахь хоосон саналын хувийн жингийн харьцуулалт



Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгогчдын “цагаан сонголт”-д шууд нөлөөлсөн болохыг баримт бичгийн судалгааны дүн харуулж байна. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны анхан болон дахин сонгуулийн үеэр хөндлөнгийн ажиглалт хийсэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газраас боловсруулсан Сонгуулийн тайланд энэ талаар дурдахдаа “Цагаан сонголт” уриалга нэлээд хүчийг авч, ялангуяа

хотын залуу сонгогчдын мэдээллийн гол эх үүсвэр болох нийгмийн сүлжээнд ихээхэн түгсэн нь санал хураалтын дүнд нөлөөлсөн.” (Ардчилсан Институт, 2017) гэх дүгнэлтэй огтлолцож байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл сонгогчдын саналд нөлөөлөхийг оролдох нь ёс зүйн зарчимд харшилсан үйлдэл болох тухайд дээрх тайланд үргэлжлүүлэн дурдахдаа “..Сайшаалтай нь, Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс ийнхүү уриалах нь сонгогчдын хүсэл зоригийг чөлөөтэй илэрхийлэхийг хязгаарласан, хөндлөнгөөс нөлөөлөх зорилготой, Сонгуулийн тухай хуулиар хориотой үйлдэл болохыг мэдэгдэв.” хэмээн дүгнэснээс үзэхэд олон улсын ажиглагчид ч мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн дээрх үйлдлийг буруушаасан нь илт байна. Мөн судалгааны ажлын хүрээнд судлаачийн зүгээс “Хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулиар иргэдэд “цагаан сонголт” хийхийг уриалах нь зөв үү?” асуулгыг нийгмийн сүлжээний хамгийн өргөн ашиглагдаж буй платформ болох Фэйсбүүк сүлжээнд 2023 оны 12-р сард долоо хоногийн хугацаанд явуулахад нийт 191 оролцогч хариулснаас олонх буюу 39.5 хувь нь “буруу”, 30.7 хувь нь “зөв”, 29.7 хувь нь “байж болно” гэж хариулсан ба “буруу” гэж харуулсан нийт оролцогчийн 80 хувийг сэтгүүлч мэргэжилтэй хариулагч эзэлж байв.

Цаашлаад олон улсын туршлага судлах интернэт хайлтын хүрээнд цуглуулсан мэдээллээс үзэхэд ч хэвлэл мэдээллийн хэрэгслээс сонгогчдын саналд нөлөөлөх оролдлого хийх нь улс төрийн зорилгод ашиглагдсан хэлбэр болохыг тодотголоо. “Хэвлэл мэдээлэл болон улс төрд итгэл алдах нь хоорондоо нягт холбоотой үйл явц бөгөөд энэ нь эрх чөлөөт нийгмийн амин судас болох Ардчилалд итгэх итгэлийг үгүй хийдэг” гэж Германы улс төр судлаач, доктор-профессор Дагмар Шипански (Шипански, 2017) хэлсэн нь бий. Энэхүү судалгаанд онцолсон хэвлэл мэдээлэл нь монгол сонгогчдын “цагаан сонголт”-д нөлөөлөгч хэдэн арван хүчин зүйлсийн ердөө нэг нь. Монгол төдийгүй дэлхий дахинд хурдацтай нэмэгдэж буй эс сонгогчдын цаана иргэдийн төрдөө итгэх итгэл алдарч, улс төрөөс хөндийрөх хандлага даамжирч байгааг нийгэм, улс төрийн харилцааны судлаачид сануулсаар байна. Энэ үзэгдэл хурцадсаар нийгэмд итгэх итгэл, хүн хүндээ итгэх итгэл, хүн өөртөө итгэх итгэлийг ч хүртэл алдруулдаг болохыг нийгмийн сэтгэл зүйч сануулжээ⁶².

Нөгөө талд, “цагаан сонголт” гэх үг нь сонгогчийн өгсөн хоосон саналын хуудсыг л илтгэх учиртай боловч манай улсад иргэний улс төрийн эсэргүүцлийн олон хэлбэрийг нэгтгэн төлөөлүүлж буй нь учир дутагдалтай байна. Иймд монголчуудын “цагаан сонголт” хэмээн нэршиж буй эсэргүүцлийн саналын тухай нэр томъёоны тодорхойлолтоос эхлээд суурь үндсээр нь судлан шинжилж, үр дагаврыг урьдчилан тооцоолох, түүнд суурилсан сонгогчдын оролцоог дээшлүүлэх олон талт алхмыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Ном зүй

Азийн сан. (2023). Монгол Улсын сонгууль /1992-2021/. УБ.
Ардчилсан Институт, Х. Э. (2017). Сонгуулийн тайлан. УБ.
С.Базарпүрэв. (2016). Улс төрд иргэд оролцох, үл оролцох учир. ПОЛИТОЛОГИ, 13-442.
А.Буяндэлгэр. (2022 оны 4). “Z Үеийхний Суралцах Арга Барилгыг Тодорхойлох нь”. www.num.edu.mn:
<https://sas.num.edu.mn/mn>
БНОУХ. (2022). Олон нийтийн санаа бодлын судалгаа. УБ.
БНОУХ. (2023). Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан. УБ: Хэвлэлийн хүрээлэн.
Ө.Ганзориг, Б. Ж. (2020). Монголын нийгмийн үеийг тодорхойлох судалгаа. УБ: “СИКА(SICA)” ХХК.
С.Ганбаатар. (2017 оны 06 30). www.zuv.mn: <https://zuv.mn/n/ak5>

⁶² “Сэтгэлзүй талаасаа төрд итгэх итгэл алдрахад нийгэмд итгэх итгэл хэврэг болж, төрд, нийгэмд итгэлгүй болсноор хүн нь хүндээ итгэхээ больж, эцэстээ энэ нь өөртөө итгэх итгэлийг ч алдруулдаг аж. Энэхүү итгэл алдарсан нөхцөл нь нийгмийн сэтгэл зүйн уруу дорой чиг хандлагыг бүрдүүлж, харин дээрх итгэлийн давхрагууд бат тогтвортой байгаа нөхцөлд нийгмийн сэтгэл зүй өөдрөг, эрч хүчтэй, урам зориг, хүсэл тэмүүлэл дүүрэн байдаг байна.” **Б.Баярцэнгэл /сэтгэл зүйч/.**

Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай. (2020 оны 12 24).
 Л.Жамбал. (2001). Улс төрийн сургаалийн түүх. Эртний үе. УБ.
 М.Зулькафиль. (2005). Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
 Монгол Улсын Үндсэн хууль. (1992. 2019 /шинэчилсэн найруулга/). УБ.
 НҮБ. (1948). Патентийн Д.д. Хүний эрхийн түгээмэл тунхаглал.
 "Нийгэм, у. т. (2021). "Z үеийн залуучуудын улс төрийн оролцоо".
 Сонгуулийн ерөнхий хороо. (2017). Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны дахин сонгуулийн дүн. УБ.
 Сонгуулийн тухай хууль. (2015 оны 12 25). gec.gov.mn: <https://gec.gov.mn/law/2536>
 Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь. (2020). УБ.
 Хэвлэлийн хүрээлэн. (2020). Хэвлэл мэдээллийн хэрэглэгчдийн судалгаа. УБ.
 Хэвлэлийн хүрээлэн. (2022). Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан. УБ.
 Г.Цэнд-Аюуш, О. (2021). Монгол Улсын 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын улс төрийн оролцооны төлөв байдалд хийсэн шинжилгээ. ПОЛИТОЛОГИ, 97-107 дахь тал.
 Шипански, Д. (2017). Хэвлэл мэдээлэлд итгэх иргэдийн итгэл. Ардчиллын III чуулган. УБ.
 Б.Эрдэнэдалай. (2021). Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиудад хийсэн улс төрийн шинжилгээ. ПОЛИТОЛОГИ, 85-96.
 GD.Schmidt. (2002). The presidential election in Peru, April 2000.
 Kate Kenski, K. H. (2017). Hybrid field of Political communication. Oxford university press.
 Kate Kenski, K. H. (2017). Hybrid field of Political Communication. Oxford university press.
 R.Michael Alvarez, D. K. (2018). A Taxonomy of Protest Voting. California: Annual Reviews.
 R.Steifbold. (1965). The significance of void ballots in West German elections. 406.
 Rosenthal, H. S. (1973). Electoral participation in the French Fifth Republic.
 Superti. (2016). The different faces of non-voting: blank voting, null voting, and voting abstention. Harvard Univ., Cambridge, MA.
 Superti. (2016). The different faces of non-voting: blank voting, null voting, and voting abstention. Harvard Univ., Cambridge, MA.
 (2020 July, 23). www.internetworldstats.com : <https://www.internetworldstats.com/asia/>
 Center, P. R. (2020). American News Pathways . Washington, D.C.: <https://www.pewresearch.org/journalism>.
 Petrosyan, A. (2023 оны 10 25). Дэлхийн интернэт хэрэглэгчдийн судалгаа. www.statista.com:
<https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide/>
www.ikon.mn. (2017 оны 06 27). Цараан сонголт ба шинэ нэр дэвшигчид.

УБ ХОТЫН НИЙТИЙН БАЙРНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, ОРШИН СУУГЧДЫН НИЙГМИЙН БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

Н. Батзориг

(Социологийн ухааны магистр, Мэргэжлийн социологичдын холбооны гүйцэтгэх захирал)

Abstract: *Social housing is the common type of housing dwelling by young families, migrants from local areas, workers, students, and low-income households. Social housing is a unique form of housing for marginalized groups of society, the middle and below-middle classes. There is no work that studies the problems of social housing and its residents at the scientific level, especially from a sociological perspective. In 2022, the author led a baseline survey team on social housing, and the results of the research are being presented to the public for the first time.*

Key word: *Social housing, young, families, migrants*

НИЙСЛЭЛ ХОТЫН НИЙТИЙН БАЙРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

2019 оны байдлаар нийслэлийн хэмжээнд 649 барилгад нийтийн байрны үйлчилгээ эрхэлж байна. Тэдгээрт 6000 орчим хүн амьдардаг байна. Хамгийн олон нийтийн байр Чингэлтэй дүүрэгт байдаг бөгөөд нийт 149 барилга тус чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж. Сонгинохайрхан 126,